Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөв буюу байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 30,718.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,898.8 мянга, нийт 37,616.8 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс Цалингийн зардалд 17,638.4 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлийн зардалд 500.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 3,828.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 12,042.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,769.4 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1,000.0 мянга, нийт 37,616.2 мянган төгрөг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 0.6 мянган төгрөг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ойрад хөгжимт жүжгийн театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Ойрад хөгжимт жүжгийн театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5,446.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 699,668.5 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 6,350.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,080.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ойрад хөгжимт жүжгийн театрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ойрад хөгжимт жүжгийн театр нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 139, хугацаа хоцроосон 10 мэдээлэл, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ойрад хөгжимт жүжгийн театр нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ойрад хөгжимт жүжгийн театрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн бөгөөд аудитаар зөрчил гараагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Ойрад хөгжимт жүжгийн театрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 253.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулж биелэлтийг ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Засаг даргын нөөцөөс “Ойрад икэль эгшиглэхүй” нэртэй 30 ширхэг номын үнэ нийт 1,350.0 мянган төгрөгийг “Эгшиглэн магнай” ХХК компанид гэрээ байгуулан шилжүүлэн бараа материалын тайланд орлогоор тусгасан байна. Тухайн ном биетээр ирээгүй байх тул дараагийн аудитаар биетээр хүлээн авсан эсэхийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,565.7 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил илэрснээс аудитын явцад 3,907.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,287.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 9,370.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Үүнд: Санхүүгийн тайланд барилга байгууламжийн элэгдлийг 3,907.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байсныг залруулга хийлгэсэн.

5.1 Албан шаардлага

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-д “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Сангийн сайдын 2012 оны

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

276 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-ноос орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг зөрчин Хөдөө сумдад хийсэн тоглолтын орлогыг Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаахгүйгээр хөндий зарлагдаж байгууллагын 57 ажилтанд нийт 3,287.2 мянган төгрөгийн үнэтэй бомбор хувцас худалдан авч өгсөн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг албан шаардлага болгосон.

2. Аудитаар илэрсэн зөрчлүүдэд холбогдуулан Ойрад хөгжимт жүжгийн театрын хөгжмийн удирдаач Б.Төгсбаяр, нягтлан бодогч Х.Өнөрдулам нарт Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өөрийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6 –д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг зөрчин “Хагас зуун жил” хөдөө бригадын тоглолтын орлогын 7,662.7 мянган төгрөгийг шууд зарлагдсан байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгов.

2. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтад “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчин өмнөх онд үүссэн суутган тооцоогүй урьдчилгааны авлага 390.0 мянга, тайлант онд тооцоогүй урьдчилгааны авлага 650.0 мянга, цалингийн тооцооллын алдаанаас илүү олгосон цалингийн авлага 667.9 мянга, нийт 1,707.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжүүдийн биелэлтийг хангаж, нотлох баримтын хамт 2023 оны 3 дугаар сарын 20 -ны өдрийн дотор манай байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Барилга байгууламжийн элэгдлийн зардал дутуу илэрхийлсэн.	1	3,907.9	1	3,907.9			1	3,907.9				
Дүн	1	3,907.9	1	3,907.9			1	3,907.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өөрийн орлого 7662.7 мянган төгрөгийг Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаагүй, хөндий зарцуулсан.	1	7,662.7					1	7,662.7				
Өөрийн орлогоос ажилтнуудад 3,287.2 мянган төгрөгийн бомбор хувцас худалдан авч өгсөн.	1	3,287.2			1	3,287.2						
Суутган тооцоогүй болон илүү олгосон цалингийн 1,707.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.	1	1,707.9					1	1,707.9				
Ойрад хөгжимт жүжгийн театрын хөгжмийн удирдаач Б.Төгсбаярт	1	-							1	-		

хариуцлага тооцуулах тухай												
Ойрад хөгжимт жүжгийн театрын нягтлан бодогч Х.Өнөрдулам д хариуцлага тооцуулах тухай	1	-							1	-		
Дүн	5	12,657.8			1	3,287.2	2	9,370.6	2	-		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Т.НАМЖИЛ/

2023 оны 02 сарын 17-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 01/05/А.20.60412
УВА-2021/34/НА-СТА-ТЧЗ

Улаангом

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ойрад хөгжимт жүжгийн театрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө сумдад хийсэн тоглолтын орлогыг Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаахгүйгээр хөндий зарлагдаж байгууллагын 57 ажилтанд нийт 3,287.2 мянган төгрөгийн үнэтэй бомбор хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-д “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж,

баталгаажуулаагүй”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2023 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Аюурзана, нягтлан бодогч Х.Өнөрдулам нарт хариуцуулав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.НАМЖИЛ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ



**АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

A. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1.Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Ойрад хөгжимт жүжгийн театрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2023/34/НА-СТА-ТШЗ
-----------------	---	-----------------	------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	---	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлагын дугаар		1.6 Огноо	2023.02.25	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	3287190
-----------------------------	--	-----------	------------	----------------------------	---------

1.8 Албан шаардлага өгөх үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Хөдөө сумдад хийсэн тоглолтын орлогыг Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаахгүйгээр хөндий зарлагдаж байгууллагын 57 ажилтанд нийт 3,287.2 мянган төгрөгийн үнэтэй бомбор хувцас худалдан авсан байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаал		
	Заалт	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6 –д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-д "Энэ тогтоол батлагдахаас өмнө			

			Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр		Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1, 4.2.1.11
	Заалт		21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”

1.9 Зөрчил барагдуулах хэлбэр /Төргөгөөр/	Улсын төсвийн дансанд		1.10 Зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд		
	Тухайн байгууллагын дансанд		
	Зөрчил арилгах		2023.07.30

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Бэлэн мөнгө хүссэн өргөдөл		2022.03.16	А.Урангэрэл
2	Үнэт цаасны борлуулалтын тооцоо		2022.08.31	“Хагас зуун жил” сумдын баргиад тоглолт
3	Ажилтнуудад олгосон жагсаалт			Хүлээн авсан гарын үсэг бүхий 57 хүний нэрсийн жагсаалт

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			Холбоо барих хаяг, утас
	Албан тушаал	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	


1	Ахлах аудитор	Т.Намжил	Ойрад хөгжимт жүжгийн театр	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Аюурзана	99647757
				Нягтлан бодогч	Х.Өнөрдулам	91287252

Албан шаардлага бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер	2023.02.15	—	
2	Дарга, тэргүүлэх аудитор	2023.02.15	—	

4.2 Албан шаардлагыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2023.02.15	

4. Албан шаардлагыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт		Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар
1	Албан шаардлагыг хүргүүлсэн албан бичгийн		Огноо	2023.02.25
			Дугаар
2	Албан шаардлагыг хүлээлгэн өгсөн	Огноо		2023.02.25
		Ажилтны	Овог нэр	Т.Намжил
			Албан тушаал	Ахлах аудитор
3	Албан шаардлагыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Ойрад хөгжимт жүжгийн театр
		Ажилтны	Овог нэр	Х.Өнөрдулам
			Албан тушаал	Нягтлан бодогч
4	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Ойрад хөгжимт жүжгийн театр
		Ажилтны	Овог нэр	Д.Аюурзана
			Албан тушаал	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

5	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо		
			Дүн		
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо			



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААР ДЛАГА

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 04/09/А2060412

Улаангом

УВА-2023/34/НА-СНА-ТЧЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойрад хөгжимт жүжгийн театрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Ойрад хөгжимт жүжгийн театрын даргаар ажиллаж байсан Б.Төгсбаярын ажлын хариуцлагатай холбоотой дараах зөрчил илэрсэн Үүнд:

1. "Хагас зуун жил" хөдөө бригадын тоглолтын орлогын 7,662.7 мянган төгрөгийг Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаахгүйгээр төсвөөс гадуур шууд зарлагдсан.
2. "Хагас зуун жил" хөдөө бригадын тоглолтын орлогоос байгууллагын 57 ажилтанд нийт 3,287.2 мянган төгрөгийн үнэтэй бомбор хувцас худалдан авч өгсөн.
3. "Ойрад икэль эгшиглэхүй" нэртэй 30 ширхэг номын үнэ нийт 1,350.0 мянган төгрөгийг "Эгшиглэн магнай" ХХК компанид гэрээний дагуу шилжүүлсэн хэдий ч тухайн номыг биетээр хүлээн аваагүй байхад бараа материалын дансанд орлого авсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "Үнэн, зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь заалтад "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.3.4 дэх заалтад "Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1 дэх заалтад "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2 дахь заалтад "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын

байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-д “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-оос орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ойрад хөгжимт жүжгийн театрын хөгжмийн удирдаач Б.Төгсбаярт сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэхийг Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Аюурзанад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.НАМЖИЛ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ





УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДИАГА

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 01/10/А 2060412
УВА-2022/34/НА-СТА-ТЧУЗ

Улаангом

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ойрад хөгжимт жүжгийн театрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Ойрад хөгжимт жүжгийн театрын нягтлан бодогч Х.Өнөрдуламын ажлын хариуцлагатай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. "Хагас зуун жил" хөдөө бригадын тоглолтын орлогын 7,662.7 мянган төгрөгийг байгууллагын Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаахгүйгээр төсвөөс гадуур шууд зарлагдсан байна.
2. Хагас зуун жил" хөдөө бригадын тоглолтын орлогоос байгууллагын 57 ажилтанд нийт 3,287.2 мянган төгрөгийн үнэтэй бомбор хувцас худалдан авч өгсөн.
3. "Ойрад икэль эгшиглэхүй" нэртэй 30 ширхэг номын үнэ нийт 1,350.0 мянган төгрөгийг "Эгшиглэн магнай" ХХК компанид гэрээний дагуу шилжүүлсэн хэдий ч тухайн номыг биетээр хүлээн аваагүй байхад бараа материалын дансанд орлого авсан.
4. Суутган тооцоогүй цалингийн урьдчилгаа өмнөх онд үүссэн 390.0 мянга, тайлант онд үүссэн 650.0 мянга, цалингийн тооцооллын алдаанаас үүдэн ажилтанд илүү олгосон цалин 667.9 мянга, нийт 1,707.9 мянган төгрөгийн авлагыг үүсгэсэн.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "Үнэн, зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь заалтад "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.3.4 дэх заалтад "Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.8 дахь заалтад "Төсвийг

зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-д “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-оос орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ойрад хөгжимт жүжгийн театрын нягтлан бодогч Х.Өнөрдуламд сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэхийг Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Аюурзанад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Т.НАМЖИЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

